



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/25

Алтай хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх хамгаалалт хийсэн газруудад услалтын систем суурилуулах (холбох хэрэгслүүд) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Баярмаа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)


М.Хандсүрэн (Хөндлөнгийн төлөөлөл)  
(тохиролцсоноор)

Б.Галсанжамц (Есөнбулаг сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: Н.Цэвэлмаа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Т.Сүхбаатар)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ